

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БҮРД СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Онгон баг, Бүрд сум, Өвөрхангай аймаг, 62025,  
Утас:8989 5365, Цахим шуудан: bu\_rd@yahoo.com

2023.11.06 № 44  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СУМЫН ЗАСАГ ДАРГА  
М.МӨНХБАЯР ТАНАА

Сумын эрүүл мэндийн төв нь их эмчийн дутагдалтай байгаа тул их боригдой 2-р багийн бага эмч Б.Гансүх нь 2022-2023 оны хичээлийн жилээс Этүгэн их сургуульд хүний их эмч мэргэжлээр суралцаж байгаа. Төгсөж ирээд төрлөх сум орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй байгаа тул сум орон нутаг дэмжиж сургалтын төлбөрийг шийдвэрлэж өгнө үү.

Данс: Этүгэн их сургууль

Хаан банк: 5041043371

ДАРГА  З.ЗОЛЖАРГАЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 1/95

Бүрд сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч Батжаргалын Гансүх нь Этүгэн Их Сургуульд хүний их эмч мэргэжлээр суралцаж байгаа бөгөөд сумын Эрүүл мэндийн төвд 5 жил ажиллах гэрээ байгуулсан тул 2023 оны сургалтын төлбөр болох 2.000.000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Сургалтын төлбөрийн дэмжлэг болох 2.000.000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Гачмаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



М.МӨНХБАЯР

## СУРГАЛТЫН ГУРВАЛСАН ГЭРЭЭ

2023 оны 11-р сарын 06-ны өдөр

№ 24

Бүрд сум

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү гэрээг нэг талаас Өвөрхангай аймгийн Бүрд сумын Засаг дарга М.Мөнхбаяр, Эрүүл мэндийн төвийн дарга З.Золжаргал нар нөгөө талаас Өвөрхангай аймгийн Бүрд сумын Эрүүл мэндийн төвийн багийн бага эмч ажилтай Батжаргал овогтой Гансүх (РД:ИЕ89101733) /цаашид суралцагч гэх/ суралцахаар харилцан тохиролцож байгуулав.

1.1 Сургалтын хугацаанд гэрээ байгуулагч талуудын хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээнээс гадна Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/337 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 тоот "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай хамтарсан тушаал болон бусад холбогдох бусад хууль, журмын хүрээнд зохицуулна.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

2.1 Энэхүү гэрээний зорилго нь төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад хэрэгцээтэй байгаа их эмч бэлтгэх улсын төсвийн болон орон нутгийн санхүүжилтээр мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, тэднийг захиалагч эрүүл мэндийн байгууллагад нь тогтвор суурьшилтай ажиллуулахад оршино.

### ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### 3.1 Захиалагч нутгийн удирдлагын байгууллагын эрх:

3.1.1 Гэрээтэй суралцагчийнхаа сургалтын үр дүнтэй холбоотой мэдээллийг авах  
3.1.2 Суралцагч нь төгссөний дараа захиалагч эрүүл мэндийн байгууллагадаа ажиллаагүй болон гэрээт хугацаагаа дуусгаагүй тохиолдолд энэ талаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлэх, хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх эсвэл холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх  
3.3.3 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд диплом, мэргэжлийн үнэмлэхийг суралцагчид олгох талаар суралцаж байгаа сургуульд мэдэгдэх

#### 3.2 Захиалагч нутгийн удирдлагын байгууллагын үүрэг:

3.2.1 Суралцагчид тавигдах шаардлага /шалгуур хангасан мэргэжилтнээ нэр дэвшүүлэх/  
3.2.2 Захиалгаар сургаж байгаа эрүүл мэндийн ажилтны мэдээлэл, холбогдох баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягталж, энэ талаар бүрэн хариуцах  
3.2.3 Захиалагч байгууллага нь суралцагчийн сургалтын төлбөрийг 4 жилийн хугацаанд гэрээнд заагдсан журам бусад эрх зүйн баримт бичигт нийцүүлэн олгох /1 дэх жилийн төлбөрийг суралцагч өөрийн зардлаар сурах, 2 дахь жилд төлбөрийн 2 сая, 3 дахь жилд 3 сая, 4 дахь жилд 3 сая төгрөгийг төлнө. /  
3.2.5 Суралцагчийн ажлын байрыг хадгалах эсвэл эзэмшсэн мэргэшлийн дагуу ажлын байраар хангаж, сургалтыг дүүргэсний дараа 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллуулах  
3.2.6 Орон нутгийн засаг, захиргааны байгууллагын дэмжлэг болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд боломжтой бусад дэмжлэгийг үзүүлэх

#### 3.3 Захиалагч эрүүл мэндийн байгууллагын эрх:

3.3.1 Гэрээтэй суралцагчийнхаа сургалтын үр дүнтэй холбоотой мэдээллийг авах  
3.3.2 Суралцагч нь захиалагч эрүүл мэндийн байгууллагадаа ажиллаагүй болон гэрээт хугацаагаа дуусгаагүй тохиолдолд энэ талаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлэх, хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх эсвэл холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх  
3.3.3 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд мэргэшлийн гэрчилгээ, үнэмлэхийг суралцагчид олгох талаар суралцаж байгаа сургуульд мэдэгдэх

#### 3.4 Захиалагч эрүүл мэндийн байгууллагын үүрэг:

- 3.4.1 Батлагдсан орон хуваарилсан мэргэшлийн чиглэлийн дагуу мэргэжилтнээ сургах
- 3.4.2 Суралцагчид тавигдах шаардлага /шалгуур хангасан мэргэжилтнээ нэр дэвшүүлэх/
- 3.4.3 Захиалгаар сургаж байгаа эрүүл мэндийн ажилтны мэдээлэл, холбогдох баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягталж, энэ талаар бүрэн хариуцах
- 3.4.4 Суралцагчийн сарын үндсэн цалин мөн дагалдах нэмэгдлүүдийг журам, бусад эрх зүйн баримт бичигт нийцүүлэн олгох
- 3.4.5 Суралцагчийн ажлын байрыг хадгалах эсвэл эзэмшсэн мэргэшлийн дагуу ажлын байраар хангаж, сургалтыг дүүргэсний дараа 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллуулах
- 3.4.6 Орон нутгийн засаг, захиргааны байгууллагын дэмжлэг болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд боломжтой бусад дэмжлэгийг үзүүлэх
- 3.4.7 Суралцах боломжоор хангаж, захиалагч эрүүл мэндийн байгууллагаас шалтгаалан сургалтыг тасалдуулахгүй байх

### **3.5 Суралцагчийн эрх:**

- 3.5.1 Сургалтын үйл явц, хөтөлбөр бусад асуудлаар санал, хүсэлт, гомдлоо эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх
- 3.5.2 Сургалтад шаардлагатай гарын авлага, сургалтын орчноор хангуулах, сургалтын чанарыг сайжруулахтай холбоотой асуудлаар холбогдох байгууллагад санал, хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх
- 3.5.3 Сургалт эрхлэх байгууллагын бусад ажилтнуудын нэгэн адил тухайн байгууллагын үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцох

### **3.6 Суралцагчийн үүрэг:**

- 3.6.1 Холбогдох журамд заасан мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцагчид тавигдах, шаардлага шалгуурыг хангасан байх
- 3.6.2 Өөрийн талаарх мэдээлэл, холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх
- 3.6.3 Шалтгаангүйгээр сургалтыг таслахгүй суралцаж, сургалтын хөтөлбөрийг амжилттай суралцаж дуусгах
- 3.6.4 Суралцагч нь тухайн жилийн сургалтын хөтөлбөрийг дуусгаж захиалагч эрүүл мэндийн байгууллагат үндсэн ажлыг амралтын хугацаан хийж гүйцэтгэх.
- 3.6.5 Сургалт эрхлэх байгууллагаас гаргасан дүрэм журмыг чанд мөрдөж, тухайн байгууллагын соёлыг хүндэтгэн, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй баг болон хамтран ажиллах
- 3.6.6 Эмчилгээ оношилгооны удирдамж, стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 4.1 Сургалтын хөтөлбөрийг биелүүлж чадаагүй, албан ёсоор чөлөө аваагүй болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтаа орхисон суралцагч нь төсвөөс гаргасан сургалтын төлбөр, тэтгэлгийг захиалагч байгууллагаас олгосон цалин бусад санхүүжилтийг тухайн байгууллагад сургалтаа орхисноос хойш буцаан төлж барагдуулна.
- 4.2 Суралцагч нь сургалтаа амжилттай дүүргэсэн хэдий ч холбогдох журам болон энэхүү гэрээнд заасан хугацаанд захиалагч эрүүл мэндийн байгууллагадаа ажиллаагүй тохиолдолд сургалтын зардлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож мөн захиалагч байгууллагаас олгосон цалин бусад санхүүжилтийг захиалагч байгууллагадаа тус тус эгүүлэн төлнө.
- 4.3 Захиалагч эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагын хариуцлагагүй, буруутай байдлаас үүдэн суралцагч нь сургалтаа амжилттай дүүргэсэн хэдий ч холбогдох журам болон энэхүү гэрээнд заасан хугацаанд захиалагч эрүүл мэндийн байгууллагад ажиллаагүй тохиолдолд суралцагч сургалтын төлбөрийг эргүүлэн төлөхгүй болно.
- 4.4 Хэрэв суралцагчийг холбогдох журам болон энэхүү гэрээнд заасан хугацаанд өөр эрүүл мэндийн байгууллагад ажилд авсан тохиолдолд уг байгууллага нь сургалтын зардлыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож захиалагч байгууллагад олгосон цалин, санхүүжилтийг захиалагч байгууллагад нь энэхүү гэрээний заасан хэмжээгээр тус тус эгүүлэн төлнө.



4.5 Хууль, журам зөрчсөн, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад нэр дэвшүүлсэн тохиолдолд тухайн суралцагчийн орон тоог шаардлагатай бусад орон нутаг/ эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

4.6 Журмын бусад заалтыг зөрчсөн талд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ

#### ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв шийдвэрлэж чадахгүй тохиолдолд маргааныг шүүхийн байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлнэ.

#### ЗУРГАА. БУСАД

6.1 Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд Засаг даргын тамгын газар, захиалагч эрүүл мэндийн байгууллага, суралцагч тус тус хадгална.

6.2 Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа нь суралцагчийг суралцаж эхэлснээс сургалтыг дүүргэж, захиалагч байгууллагадаа 5 жил ажиллах хугацаанд хүчинтэй.

6.3 Гэрээний хувьд адил тэгш хүчинтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээнд аль нэг талын санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилж болох бөгөөд энэ тохиолдолд бусад талуудад урьдчилан мэдэгдсэн байна.


#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### ЗАХИАЛАГЧ:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН  
ЗАСАГ ДАРГА  
МАНАТЖАВ ОВОГТОЙ МӨНХБАЯР

  
.....  
(гарын үсэг)

ӨВӨРХАНГАЙ БҮРД СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
ЗОЛБИН ОВОГТОЙ З.ЗОЛЖАРГАЛ

  
.....  
(гарын үсэг)

##### СУРАЛЦАГЧ:

Өвөрхангай аймаг Бүрд сумын эрүүл мэндийн төвийн 2-р багийн эмч ажилтай  
Батжаргал овогтой Гансүх

.....  
(гарын үсэг) (РД:ЙЕ89101733 Утас: 89101733)